

BRINKS ETHICS & COMPLIANCE

BRINK'S НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

2025 оны 1-р сар

ГАРЧИГ

Хуулийг мөрдөх.....	3
Хүний эрхийг хангах.....	3
Хүүхдийн хөдөлмөр ба албадан хөдөлмөр	3
Хамтрах эрх чөлөө.....	4
Ажлын байрны хөдөлмөр хамгаалал ба эрүүл ахуй	4
Ялгаварлан гадуурхлын эсрэг	4
Орчин.....	4
Ашиг сонирхлын зөрчил.....	4
Бэлэг, хоол, зугаа цэнгэл.....	5
Хээл хахууль	5
Мөнгө угаалтын эсрэг	5
Бизнес ба санхүүгийн бүртгэл	6
Монополийн эсрэг журам ба шударга өрсөлдөөний туршлага.....	6
Мэдээллийг хамгаалах	6
Хувийн мэдээллийг хамгаалах	6
Сахилгын зөрчлийг мэдээлэх	7

Brink's болон түүний холбогдох хэсгүүд, дэлхий дахинд байгаа охин компаниуд, салбар компаниуд (хамтад нь "Brink's" гэх) өөрийн бизнесээ үнэнч шударгаар, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явуулж, тодорхой үүргийг хүлээсэн бизнесүүдтэй түншлэн ажиллах үүргийг хүлээнэ.

Энэхүү ёс зүйн дүрэм нь Бринкст бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлдэг нийлүүлэгч, борлуулагч, ажил гүйцэтгэгч, лиценз эзэмшигч, төлөөлөгч (хамтад нь "Нийлүүлэгч") зэрэг хүн бүрд хамаарна. Энэхүү дүрмээр бидний хүлээлтийг хамгийн доод хэмжээг тодорхойлно.

Хуулийг мөрдөх

Brink's-ийн бүх нийлүүлэгч (туслан гүйцэтгэгчдийг оролцуулаад) хөдөлмөр эрхлэлт, цагаачлал, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, орчинтой холбоотой олон улсын, үндэсний, мужийн, орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй тохиолдолд уг бизнесийн харилцааг шууд дуусгавар болгох шалтгаан болно.

Хүний эрхийг хангах

НҮБ-н олон улсын Гэрээний гишүүний хувьд Brink's Хүний эрхтэй холбоотой НҮБ-ын зарчмуудыг дэмжих үүрэг хүлээдэг. Бид тэдгээр зарчмуудыг дагаж мөрдөх үүргээ бүх нийлүүлэгч түншүүдийнхээ үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

Нийлүүлэгчид Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын 2015 оны Орчин цагийн боолчлолын тухай хуулиас гадна хүний эрхтэй холбоотой бүх хууль, дүрэм, тогтоол, журмыг (туслан гүйцэтгэгч бүрээ түүнийг дагаж мөрдөж байгаа эсэхийг нягтлах) заавал дагаж мөрдөнө.

Нийлүүлэгчид өөрсдийн хангамжийн сүлжээндээ боолчлол, хүүхдийн хөдөлмөр эсвэл хүний наймаагаар үл хязгаарлагдах хүний эрхийн зөрчил байхгүй эсэхийг нягтлахын тулд өөрсдийн нийлүүлэгчид, туслан гүйцэтгэгчид ба бусад оролцогчдоо магадлан шалгах журмыг хэрэгжүүлнэ. Хэрэв борлуулагчид өөрсдийн хангамжийн сүлжээн дэх зөрчлийг мэдвэл түүнийг Бринкст даруй мэдэгдэнэ.

Хүүхдийн хөдөлмөр ба албадан хөдөлмөр

Brink's насанд хүрээгүй хүүхдийг ашиглах эсвэл албадан хөдөлмөр эрхлэлтийг үл тэвчих бөгөөд тэдгээр бүлгийн аль нэгэнд хамаарах хүмүүсийг ажилтан болгон ашигладаг нийлүүлэгчтэй ажиллахгүй. Нийлүүлэгчид зөвхөн хуулийн насны доод шаардлагыг хангасан ажилтнуудыг ажиллуулах бөгөөд хүүхдийн хөдөлмөртэй холбоотой бүх хуулийг дагаж мөрдөнө. Brink's НҮБ-н Даян Дэлхийн гэрээний чиглүүлэх зарчмуудыг хүүхдийн болон албадан хөдөлмөрийг үр дүнтэй цуцлах зэргийг дэмжиж, нийлүүлэгчдээ ч тэдгээр зарчмуудыг мөрдөж ажиллахыг шаардана.

Нийлүүлэгчид ажилтнуудаа завсарлагаа, амралт, жирэмсний болон эцгийн амралтыг багтаасан тогтмол ажлын цаг ба илүү цагаар ажиллахтай холбоотой хуулийн дагуу ажиллаж байгаа эсэхийг нягтална.

Хамтрах эрх чөлөө

Бид нийлүүлэгчдээ бүтээмжтэйгээр оролцож ажиллах, тэднийг тогтвортой бизнесийн чухал үнэт зүйл гэж үнэлэхийг эрмэлзэнэ. Нийлүүлэгчид нь ажлын нөхцөлтэй холбоотойгоор ажилчдын хамтрах, үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажлын зөвлөл байгуулах, хамтын тохиролцоо зэрэг хөдөлмөрийн хэлэлцээр хийх эрхийг хүндэтгэх ёстой. Нийлүүлэгч тухайн хамтралд оролцох ажилтныг айлган сүрдүүлэх эсвэл доромжлохыг хориглоно.

Ажлын байрны хөдөлмөр хамгаалал ба эрүүл ахуй

Нийлүүлэгчид нь ажилчдадаа аюулгүй ажиллагааны хяналт, журам, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хамгаалах хэрэгсэл, ажиллах таатай орчин бүрдүүлэх ба үүнтэй холбоотой хууль журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Ялгаварлан гадуурхлын эсрэг

Бринкст бид хувь хүний болон соёлын ялгааг хүндэтгэж, ялгаварлан гадуурхлыг үл тэвчдэг.

Нийлүүлэгчид ялгаварлан гадуурхалгүй ажлын байрыг хадгалах, ажилтны арьс өнгө, хүйс, жирэмсний байдал, хүйс, гэрлэлтийн байдал, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, нас, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал үүсэл, үндэсний гарал үүсэл, тухайн ажлыг хийхэд шаардлагатай ажил хийх хувь хүний чадвартай холбогдолгүй бусад шинж чанаруудаас бусад тэдний ур чадвар тулгуурлан хуулийн шаардлага хангасан ажилчдыг авч ажиллуулах ёстой.

Бринкст, манай цөм үнэ цэний нэг бол олон талт байдал ба оролцоо юм. Бид тэгш боломжийг дэмждэг нөөцийн процесст нийлүүлэгчдээ оролцохыг шаардана.

Орчин

Brink's өөрсдийн нийлүүлэгчдээс үйл ажиллагаандаа хог хаягдал, агаарын бохирдол, хорт хийн ялгарал, хорт бодис, аюултай хог хаягдал хаяхтай холбоотой бүх хууль дүрмийн шаардлагыг хангасан мөн байгаль орчны тухай хуулийн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаардана. Нийлүүлэгчид бүх материал болон найрлагыг тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлэхээс гадна олон улсын гэрээ, протоколуудад нийцсэн зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс авсан эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Мөн түүнчлэн нийлүүлэгчид өөрийн үйл ажиллагаа болон үйлчилгээндээ хог хаягдал, хорт хийн ялгарлыг багасгах, түүнийг дэмжсэн хөтөлбөрийг зохиож мөрдөх, аргуудыг тогтмол эрэлхийлэхийг шаардана.

Ашиг сонирхлын зөрчил

Brink's ажилтнууд үргэлж компанийнхаа ашиг сонирхлыг дээд хэмжээнд тавьж ажиллах шаардлагатай. Иймдээ ч ажилтнууд ямар нэгэн байдлаар нийлүүлэгчтэй хувийн харилцаа үүсэх, ашиг сонирхолын зөрчил үүсгэсэн эсвэл үүсгэж болзршгүй альваа санхүүгийн харилцааг хориглох ба Brink's ашиг сонирхлыг хамгийн дээд хэмжээнд тавьж ажиллах нь бүх ажилчдын үүрэг юм.

Бизнесийн шийдвэрт нөлөөлөх зорилгоор Brink's ажилтнуудад хувийн бэлэг, тусламж, хувийн аяллын зардал, байр, бусад орон сууц, бүх төрлийн үйлчилгээ, хэт үнэтэй хоол эсвэл зугаа цэнгэл (доороос дэлгэрэнгүйг үз) бусад үнэ цэнэ бүхий зүйлийг санал болгох, өгөх, төлөх зэргийг багтаасан ашиг сонирхлын зөрчил үүсгэх үйлдлүүдээс нийлүүлэгчид зайлсхийх шаардлагатай.

Бэлэг, хоол, зугаа цэнгэл

Brink's-ийн ажилтнууд нийлүүлэгчдээс энгийн бэлэг, хоол, зугаа цэнгэлээс илүү зүйл хүлээн авахыг хориглоно. Бэлэн мөнгөний бэлэг эсвэл бэлгийн картууд зэрэг бэлэн мөнгөтэй тэнцэх зүйл авахыг хатуу хориглоно. Brink's-ийн ажилтнууд нь харилцагчид эсвэл бизнесийн бусад түншүүдээс бэлэг, хоол эсвэл зугаа цэнгэл санал болгох үед энэ хэсэгт тодорхойлсонтой ижил хязгаарыг нийлүүлэгчийн ажилтнуудад тавина.

Хээл хахууль

Үнэнч шударга байдал бол Brink's-ийн гол үнэ цэн бөгөөд нийлүүлэгч болон түншүүдээсээ бизнесийн үйл ажиллагаандаа ёс зүйн хамгийн дээд стандартыг дагаж мөрдөхийг шаардана. Brink's-ийн өмнөөс ажил гүйцэтгэж буй нийлүүлэгчидээс АНУ-ын Гадаадын авилгын тухай хууль, Их Британийн Авилгын тухай хууль болон үйл ажиллагаа явуулж буй улсын авилга хээл хахуулийн эсрэг бүхий хууль дүрмийг дагаж мөрдөнө. Нийлүүлэгчид Brink's-ийн оролцоотой альваа үйл ажиллагаанд шудрага бус байдлаар давуу тал олох, нөлөөлөх зорилгоор шууд болон шууд бус байдлаар төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, улс төрийн нам зэрэгт үнэ бүрий зүл дамжуулахыг хориглоно.

Нийлүүлэгч нь Brink's-ийн нийлүүлэгчийн үндсэн харилцах/харилцааны менежерээр дамжуулан Brink's-ээс эрх зүйн зөвлөхөөс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Brink's-ийн өмнөөс (эсвэл Brink's-ийн өмнөөс засгийн газартай харилцахдаа) төрийн албан хаагчд ямар хэмжээний үнэ бүхий зүйл өгөхийг хориглоно.

Brink's- худалдааны авилгыг ч хориглодог. Нийлүүлэгчид Brink's-ийн өмнөөс хийсэн бүх төлбөрийн (бэлэг, хоол, зугаа цэнгэл эсвэл өөр үнэ цэнтэй зүйлийг оролцуулаад) бүртгэлийг бичгээр хадгалах ёстой. Нийлүүлэгчид энэхүү бүртгэлийн хуулбарыг Brink's-ийн хүсэлтээр ирүүлж байна.

Мөнгө угаалтын эсрэг

Brink's-т бид Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг ("AML") бүх хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөж ажилдаг. Brink's-ийн өмнөөс ажиллаж байхдаа нийлүүлэгчид хууль бус үйл ажиллагаанаас олсон орлоготой холбоотой хэлцэлд оролцохгүй эсвэл оролцох оролдлого хийхгүй, холбогдох мөнгө угаалтын эсрэг болон бусад зохицуулалтын хариуцлагыг итгэлцлийн хамгийн дээд хэмжээнд хүлээж ажиллах ба, хууль бус үйл ажиллагаатай холбоотой сэжиг бүхий зүйлийг бидэнд даруй мэдээлнэ. Бид олон улсын эдийн засгийн хоригтой нэр цохсон хувь хүн ба аж ахуйн нэгжүүдтэй (тухайлбал сэжигтэй террористууд эсвэл хар тамхи наймаалагчид) хэлэлцээр хийхгүй байхыг нийлүүлэгчдээс шаарддаг.

Бизнес ба санхүүгийн бүртгэл

Brink's-тэй хийх нийлүүлэгчийн бизнестэй холбоотой бүх асуудлын бүртгэлийг Нийлүүлэгч болон Brink's хоёул үнэн зөв хөтөлнө. Үүнд бүх зардал ба төлбөрийн зохистой бүртгэл багтана. Хэрвээ Brink's- нийлүүлэгчийн ажилтаны цагаар төлбөр бодох бол цагийн бүртгэлийг бүрэн, үнэн зөв хөтөлсөн байхыг шаардна. Нийлүүлэгчид нэхэмжлэх илгээхдээ хоцроож болохгүй бөгөөд хоцроосон тохиолдолд өөр нягтлан бодох бүртгэлийн хугацаанд шилжих боломжийг олгоно.

Монополийн эсрэг журам ба шударга өрсөлдөөний туршлага

Нийлүүлэгчид өөрсдийн бизнес эрхэлж буй улс оронд мөрдөгддөг монополийн эсрэг ба шударга өрсөлдөөний тухай хуультай бүрэн нийцэж бизнесийн үйл ажиллагаагаа явуулна. Нийлүүлэгчид шударга бизнесийн стандарт болон шудрага өрсөлдөөний зарчмыг баримтлаж, альваа шудрага бус өрсөлдөөнийг дэмжсэн монополийн хуулийг зөрчсөн үйлдэлд хүргэж болзошгүй гэрээнээс татгалзана. Тухайлбал нийлүүлэгчид өрсөлдөгчидтэйгээ үнэ тогтоох, тендерт оролцох, бизнесийн нөхцлүүдийг тохиролцох, зах зээлээ хуваалцах, шудрага өрсөлдөөний эсрэг бойкотлох (өрсөлдөгчдийн хоорондын харилцагч ба борлуулалтын газар нутгийн хуваарилалт зэрэг) альваа хууль бус үйлдэл болон мэдээлэл солилцох ках кээлийн ямар нэгэн зохицуулалт хийхийг хориглоно.

Мэдээллийг хамгаалах

Нийлүүлэгчид Brink's нууц мэдээллийг хамгаална. Бизнесийн харилцааны нэг хэсэг болсон нууц мэдээлэлд нэвтрэх эрх олгогдсон нийлүүлэгчид Бринксээс тусгайлан авсан зөвшөөрөлгүйгээр хэнтэй ч тухайн мэдээллийг дамжуулахыг хориглоно. Бид нийлүүлэгчдээ холбогдох аюулгүй байдал, хувийн нууцлалын хуулиуд, хууль тогтоомж, хадгалах шаардлагыг дагаж мөрдөх, болон зохих техникийн, аюулгүй байдлын хяналтаар нууц мэдээллийг хамгаалж байгаа эсэхийг нягтлахыг шаарддаг.

Нууц мэдээлэлд бизнесийн төлөвлөгөө, үнийн стратеги, маркетингийн төлөвлөгөө, ажилтаны хувийн мэдээлэл, харилцагчийн мэдээлэл, оюуны өмч гэсэн Brink's нийтийн бус бүх мэдээллийг хамааруулдаг. Нийлүүлэгчид энэ мэдээллийг гэрээнд болон компанитай байгуулсан нууцлал хадгалах гэрээнд заасан шаардлагаас гадуур аутсорсинг хийх, задлах, хуваалцах, ашиглахыг хориглоно.

Нийлүүлэгчид Бринкст үйлчилгээ үзүүлэх эсвэл түүний өмнөөс ажиллаж байхдаа хүлээн авсан нууц мэдээлэлд тулгуурлан Brink's үнэт цаасыг арилжихыг хориглоно. Хэрвээ нийлүүлэгч Brink's юмуу аливаа гуравдагч этгээдийн нууц мэдээлэлд алдаа гарсны улмаас түүнд нэвтрэх эрх олгогдсон гэж үзвэл тухайн нийлүүлэгч энэ талаар Бринкст даруй мэдэгдэж, уг мэдээллийг цааш тархахаас сэргийлнэ.

Хувийн мэдээллийг хамгаалах

Дээрх нууц мэдээллээс гадна Brink's өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа Brink's ажилтнууд юмуу гуравдагч этгээдээс хувийн мэдээлэл авсан аливаа нийлүүлэгч тухайн мэдээллийг хуулийн дагуу цуглуулсан, зохисгүй хандалт, хэрэглээ, задруулалтаас хамгаалах, зохих ёсоор боловсруулсан, нийлүүлэгчээс холбогдох эрх бүхий газарт зохих материалыг бүрдүүлж өгсөн эсэхийг заавал нягтална.

Сахилгын зөрчлийг мэдээлэх

Brink's ажилтан эсвэл Brink's өмнөөс ажиллаж байгаа хүн хууль бус эсвэл ёс зүйгүй үйлдэл гаргаж байна гэж үзвэл нийлүүлэгчид энэ асуудлыг шууд Бринкст даруй мэдэгдэнэ.

Асуудлыг мэдээлэхийн тухайн ажилтаны менежерт шууд эдэгдэх эсвэл Brink's-ийн Ёс зүйн лавлах утсаар асуудлыг мэдээлж болно. <https://brinkshotline.ethicspoint.com> (30 гаруй хэлээр мэдээлэл оруулах боломжтой) хаягаар зөрчил мэдээллэж болох ба мөн орон нутгийн лавлах утасны дугаарыг энэ сайтнаас авах боломжтой.

Зөрчлийг үнэнчээр мэдээлэх нь Бринкс болон нийлүүлэгчийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй.